

**МОНГОЛ УЛС, ХБНГУ-ЫН СЭРГЭЭН БОСГОЛТЫН ЗЭЭЛИЙН БАНК
ХООРОНД ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛЖ, “ТӨВИЙН БҮСИЙН
ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ТӨСЛИЙН III ҮЕ ШАТ”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН
ТАЛААР**

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК (цаашид “ЦДҮС” ТӨХК” гэх) нь төслийн эцсийн зээлдэгч бөгөөд Эрчим хүчний яамны харьяанд цахилгаан дамжуулах сүлжээ буюу 110, 220 кВ-ын хүчдэлийн түвшний цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах үйлчилгээг эрхэлдэг төрийн өмчит байгууллага юм.

**1.УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ХЭСГИЙН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХАНГАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын төвийн хэсгийн цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийг хангадаг 110 кВ-ын хүчдэлийн түвшний Өмнөд, Умард, Дорнод-2 болон Туул дэд станцууд нь суурилагдсан хүчин чадлын 70-100 хүртэл хувь ачаалагдсан, чадлын нөөц боломжгүй, 40 буюу түүнээс дээш жилийн насжилттай, шинээр хэрэглэгч холбох боломжгүй хүндрэлтэй нөхцөлд ажиллаж байна.




Зураг 1. УБ хотын төвийн дэд станцуудын насжилт, ачааллын зураглал

Өнөөдрийн байдлаар Эрчим хүчний яаманд хандсан 49,3 МВт хэрэглээ бүхий ачаалал цахилгаан эрчим хүчинд холбогдох, хангагдах боломжгүй байна.

Энэ нь хотын төв хэсгийг цахилгаан эрчим хүчээр хангаж буй дээр дурдсан дэд станцууд техникийн хүчин чадлын хүрэлцээгүй болсноос шалтгаалж буй тулгамдсан асуудал болно.

Иймд дээрх хүчин чадлын дутагдлыг хангахад хотын төв хэсэгт 110 кВ-ын хүчдэлийн түвшний шинэ дэд станц барих зайлшгүй шаардлагатай байна.

АЧААЛАЛ ХУВИАР /%/



Зураг 2. Хотын төвийн хэрэглээг хангаж буй дэд станцуудын төсөл хэрэгжихээс өмнөх болон дараах ачааллын судалгаа, таац

2. ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Нийслэл Улаанбаатар хотын төв хэсэгт 1-р зэрэглэлийн хэрэглэгчид болох Улсын төв эмнэлгүүд, Төрийн ордон, яамд зэрэг нийт 5 дүүргийн 50,884 цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид байдаг.



Зураг 3. Шинээр баригдах дэд станцаас тэжээгдэх бүсчлэл

Мөн Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг Нийслэлийн бүтээн байгуулалтыг дэмжих жилээр зарласантай холбогдуулан хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй “Улаанбаатар трамвай”, “Шинэ цэнгэлдэх хүрээлэн”, “Дүүжин замын тээвэр” болон “Улаанбаатар метро” барих төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хотын төвд шинээр 110 кВ-ын дэд станц барьснаар хангах нөхцөл бүрдэх юм.

3. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР БА KFW БАНКНЫ ДЭМЖЛЭГ

Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банктэй хамтран Монгол Улсын эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, мөн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийг үе шаттай хэрэгжүүлж байна.

Төслийн өмнөх үе шатанд тус банкны 20.45 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дэвшилтэд технологи бүхий стандартын шаардлагад нийцсэн реле хамгаалалт, автоматикийн тоног төхөөрөмжүүд болон элегаз таслууруудыг “ЦДҮС” ТӨХК-ийн дэд станцуудад суурилуулсан. Ингэснээр цахилгаан тоноглолоос шалтгаалж үүсэх гэмтэл, тасралтын тоо буурах, дотоод хэрэгцээ, дутуу түгээх цахилгаан эрчим хүчний хэмжээг багасгах замаар түүхий нүүрсний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, эрчим хүчний салбарын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн юм.

4.МОНГОЛ УЛСЫН БОДЛОГЫН ДЭМЖЛЭГ

110/10 кВ-ын 2х63 МВА чадалтай “Өргөө” дэд станц, 110 кВ-ын 4.0 км урттай ЦДКШ барих төсөл нь дараах бодлогын баримт бичигт туссан буюу нийцэж байгаа болно. Үүнд:


- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд – “8.Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна”;

- Шинэ сэргэлтийн бодлого: Эрчим хүчний сэргэлт – “2.1.Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ”;

- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр: “1.1.2.5.Парк, Дамбадаржаа, Баянхошуу, Их наран дэд станц, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барина” гэж тус тус заасан байна.

5.ТӨСЛИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг “ЦДҮС” ТӨХК гүйцэтгэж, Эрчим хүчний яамны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн. Зураг төслийг “Бодит чадал” ХХК шинээр боловсруулсан 110 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын норм, стандартад нийцүүлэн боловсруулсан. Санхүүжилт шийдэгдсэн нөхцөлд дэд станцыг 1-1,5 жилд ашиглалтад оруулах боломжтой.



Зураг 4. Шинээр баригдах дэд станцын төлөвлөлт

6. САНХҮҮЖИЛТ БА БАРИЛГЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЯВЦ, БЭЛТГЭЛ

Төслийн бэлтгэл ажлын хүрээнд дэд станцын барилгыг барихад шаардлагатай 0.12 га газрыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар “ЦДҮС” ТӨХК-ийн эзэмшилд авсан. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт 17.0 сая еврогийн хөрөнгө оруулалтыг ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкны зээлийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжтой.

7. ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ГАРАХ ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ

Төслийн хүрээнд шинээр 110/10 кВ-ын 2x63 МВА чадалтай хаалттай дэд станц, 110 кВ-ын 4.0 км урттай хос цахилгаан дамжуулах кабель шугам барьж, одоо байгаа 110/35/10 кВ-ын Туул дэд станцыг өргөтгөх ажлуудыг гүйцэтгэнэ.

Ингэснээр Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Баянзүрх зэрэг 5 дүүргийн 14 хорооны хотын төвийн хэсгийн 1-р зэргийн хэрэглэгчид болох Төрийн ордон, Улсын төв 1-р эмнэлэг, 2-р эмнэлэг, Өргөө амаржих газруудын SAIFI (System Average Interruption Frequency Index) 0.21 болж олон улсын жишигт хүрэх, бусад 11,832 хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж, иргэн болон аж ахуйн нэгжийн хүлээгдэж буй 49.4 МВт чадлын хэрэглээ хангагдах, нэмэлтээр 30-40 МВт-ын шинэ хэрэглэгч холбогдох техникийн боломж бүрдэнэ.

Мөн Улаанбаатар хотын төвийн хэсгийн хэрэглэгчдийг хангаж байгаа Умард, Туул, Өмнөд, Дорнод-2 дэд станцуудаас 25-30 МВт-ын шинэ хэрэглэгч холбогдох техникийн боломж бүрдэнэ.

8.ТӨСЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ:

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрчим хүч дамжуулах шугам нь төрийн өмчлөлд байхаар хуульчилсан, нийгмийн дэд бүтэц ба цэвэр мөнгөн урсгалыг өндөр хэмжээгээр төвлөрүүлэхэд хүндрэлтэй, шууд орлого олдоггүй учир IRR хувьд харьцангуйгаар бага байна. Олон улсад хэрэгжиж буй төслүүдийн хувьд 5-15%-д хэлбэлздэг бол “Өргөө дэд станц”-ын IRR нь 1.0 хувьтай тооцоологдсон.

Хэдийгээр төслийн өгөөж бага байгаа ч хотын төвийн 1-р зэрэглэлийн цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийн найдвартай, аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, мөн Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй хөгжлийн томоохон төслүүд цахилгаан эрчим хүчээр хангах Өргөө 110/10 кВ-ын дэд станц, ЦДКШ /Цахилгаан дамжуулах кабель шугам/ барих төсөл нь нийгэм, дэд бүтцийн өндөр ач холбогдолтой төсөл юм.

---oOo---